



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/582

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цаг уурын гамшигт болон аюулт үзэгдлийн үед шуурхай арга хэмжээ авч ажиллах дайчилгааны төлөвлөгөө” боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Я.Эрхэмбаяр (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Л.Ариунаа (Мал эмнэлгийн газрын дарга)

Гишүүд:

Хурандаа Ё.Пүрэвсүрэн (Онцгой байдлын газрын дарга)

С.Батхуяг (Цэргийн штабын дарга, Хурандаа)

М.Мөнх-Аюуш (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Т.Раднаабүд (Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ө.Баттулга (Авто тээврийн төвийн дарга)

З.Бадрал (“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ний захирал)

Ж.Даваахүү (“Мэдээлэл харилцаа холбоо, сүлжээ” ТӨХК-ний захирал)

Б.Өнөрбат (Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)

Б.Галбадрах (“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ний захирал)

Б.Санжаа (“Хөвсгөл зам” ХХК-ний захирал)

Ч.Дашбаяр (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

Ө.Орхон (Хөвсгөл аймаг дахь Нефть хангамжийн салбарын захирал Ник Петровис ХХК)

Г.Чинчулуун (Улаан загалмайн хорооны дарга)

Сумдын Засаг дарга нар

2.

2. Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох заавар, зөвлөмжийг өгч, мэргэжлийн удирдлагаар хангаж 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн дотор төлөвлөгөөг боловсруулан танилцуулж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ё.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газар (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ